

**2025 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАН БУЮУ НЭГЖИЙН ДАРГА)**

Байгууллагын нэр: Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар
Нэгжийн нэр: Цэргийн штаб

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
1.	6 үндсэн зорилтын хүрээнд 50 ажил, арга хэмжээ	Биелэлтийн хувь = 98.2%	(Биелэлтийн хувь * 70 / 68.7 оноо

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Арга хэмжээ 1.	95,2%	14.0
2.	Арга хэмжээ 2.	100%	15.0
3.	Арга хэмжээ 3.	100%	15.0
4.	Арга хэмжээ 4.	97,5%	14.0
5.	Арга хэмжээ 5.	100%	15.0
6.	Арга хэмжээ 6.	96,9%	14.0
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			14,5

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	15.
2.	Удирдан зохион байгуулах	14
3.	Асуудал шийдвэрлэх	14
4.	Манлайлах	14
5.	Багаар ажиллах	15
6.	Харилцаа	15
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		14,5

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)	68,7.
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	14,5

	(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	14,5
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	—
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		97,7.

Үнэлгээ өгсөн:

ЗДТГ-ын дарга
(албан тушаал)

Төсвийн шууд захирагч

.....
(гарын үсэг)

/Ш.Эрдэнэбат/
(албан хаагчийн нэр)

2025.12.09 (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

Цэргийн штабын дарга
(албан тушаал)

Нэгжийн дарга

.....
(гарын үсэг)

/Д.Төмөрбаатар/
(албан хаагчийн нэр)

2025.12.09 (огноо)

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЦЭРГИЙН ШТАБЫН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
АЖЛЫН ТАЙЛАН

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хэрэгжилт	Хувь
1. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ							
1.1	Цэргийн штабын “Сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-г боловсруулан БХЯ-ны төрийн нарийн бичгийн даргаар батлуулах.	-	Сургалтын нэгдсэн төлөвлөгөөний биелэлт, үр дүн	100%	Сургалтын нэгдсэн төлөвлөгөөний биелэлт 100%	Цэргийн штабын “Сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-г батлан хамгаалах яамны холбогдох албан тушаалтнуудаар хянуулж Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан төлөвлөгөөнд заагдсан сургалтад холбогдох хүмүүсийг оролцуулж биелэлтийг ханган ажилласан.	100%
1.2	МУ-ын алсын хараа 2050 урт хугацааны хөтөлбөр, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Шинэ сэргэлтийн бодлогод Батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан арга хэмжээг орон нутагтаа хэрэгжүүлэх.	ОНТ	Төлөвлөгөөний биелэлт үр дүн	100%	100%	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчлэх, хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, “Оюутан-цэрэг” сургалтад суралцагчдын тоог нэмэгдүүлэх, цэргийн хугацаат болон гэрээт алба хаагчдын алба хаах хугацаанд амьдрах, ажиллах нөхцөлийг сайжруулах гэсэн 3 арга хэмжээг аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавин ажиллалаа.	100%

1.3	Монгол улсын Засгийн газрын батлан хамгаалах зарим чиг үүргийг Говь-Алтай аймагт төлөөлөн 2025 онд хэрэгжүүлэх гэрээнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэх.	ОНТ	Гэрээний биелэлт үр дүн	94,6%	90%-с дээш	Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Говь-Алтай аймагт төлөөлөн 2025 онд хэрэгжүүлэх гэрээний дагуу иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, орон нутагт батлан хамгаалах бодлого, зорилт, зэвсэгт хүчний үйл ажиллагааг аймгийн иргэд, хөдөлмөрчид, цэргийн насны залуучуудад сурталчлах, орон нутгийн хамгаалалтын сургалт бэлтгэлийг зохион явуулах талаар гэрээнд тусгасан 5 бүлэг, 32 нэр төрлийн ажил үйлчилгээг орон нутагт хэрэгжүүлэн ажиллалаа.	92%
1.4	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангах.	ОНТ	Төлөвлөгөөний биелэлт үр дүн	100%	100%	Аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөнд 3 зорилт 5 арга хэмжээг тусгаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
1.5	Аймгийн эдийн засаг, нийгмийг 2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан бодлогын зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангах.	ОНТ	Төлөвлөгөөний биелэлт үр дүн	100%	Төлөвлөгөөний биелэлт 90%-с багагүй	Аймгийн эдийн засаг, нийгмийг 2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан бодлогын зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.	100%
1.6	Аймгийн ЗДТГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд цэргийн штабаас тусгасан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг хангах.	ОНТ	Төлөвлөгөөний биелэлт үр дүн	100%	100%	Аймгийн ЗДТГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд цэргийн штабаас 3 зорилт арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа.	100%
1.7	"Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын дээд зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө", "Орон нутгийн хамгаалалт", "Орон нутгийн цэргийг байгуулах бэлтгэлийг хангах төлөвлөгөө"-нүүдийг тодотгох орон нутгийн	ОНТ	Төлөвлөгөөний биелэлт үр дүн	90%	70%	Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө", "Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө"-г тодотгон сумдын орон нутгийн отряд, сумангийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган томилгоот бүрэлдэхүүн, хүч хэрэгсэл, машин техникүүдийг тодотгон нөхөн хангалт	90%

	хамгаалалтын тогтолцоог нутаг дэвсгэртээ бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх.				хийж орон нутгийн хамгаалалтын томилоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сурталтыг зохион явуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.	
1.8	Батлан хамгаалахын хууль тогтоомж, Батлан хамгаалахын сайдын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх, хяналт тавих	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	100%	Үйл ажиллагааны хэрэгжилтээр 100%	100%
					Монгол Улсын Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн газрын 2024 оны мн/243 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2025 оны мн/05 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2025 оны "нэгдүгээр зэлжийн цэрэг татлага явуулах тухай" А/131 дүгээр захирамжийг тус тус удирдлага болгон хугацаат албаны цэрэг татлагыг 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс 05 дугаар сарын 02-ний өдрүүдэд зохион байгууллаа.	
					Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 2025 оны А/159 дүгээр захирамжийн хүрээнд аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах Цэрэг-спортын "Дөл-2025" цогцолбор тэмцээнийг 2 үе шаттай зохион байгуулж явууллаа. Батлан хамгаалах сайдын 01, 02 албан даалгаврууд болон тухайн албан даалгавруудыг үндэслэн гарсан Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаал, мөн даргын 17/395 тоот албан даалгавруудын дагуу төлөвлөгөө боловсруулан үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган тайлан мэдээг сар бүрээр хүргүүлэн ажиглаж байна. Сумдад батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилт, иргэний цэргийн үүргийн биелэлтэд хяналт тавих, сумдын дайчилгааны болон орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилт, тодотгол хийсэн байдал,	

					хадгалалт хамгаалалт, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд ажилладаг 18-55 насны цэргийн үүрэгтний цэргийн үүргийн биелэлтэд хяналт шалгалтыг явуулж зөрчилтэй иргэдийн зөрчлийг арилгуулах, цэргийн албатай холбоотой төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах арга хэмжээг 2025 оны нэгдүгээр ээлжийн цэрэг таглагатай хамтатган зохион явуулаа.	
--	--	--	--	--	---	--

2. ЗАСАГ ДАРГА, ТАМГЫН ГАЗРЫН ДАРГАД ҮЗҮҮЛЭХ ЗАХИРГААНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

2.1	МУ-ын Засгийн газар, Батлан хамгаалах салбар болон Засаг даргын үйл ажиллагаатай холбоотой арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах.	ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	97,2%	үйл ажиллагааны хэрэгжилтээр 100%	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт батлан хамгаалах салбарын талаар тусгагдсан зорилтуудаас орон нутагт хамааралтай заалтуудыг аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны "хөтөлбөр" төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын батлан хамгаалах зарим чиг үүргийг Говь-Алтай аймагт 2025 онд төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ, аймгийн ЗДТГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөө, цэргийн штабын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө зэрэг бодлогын бичиг баримтуудад батлан хамгаалах бодлого, хууль тогтоомж үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр 4 зорилт арга хэмжээг тусган хэрэгжүүлж ажиллалаа.	100%
2.2	Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомж, үйл ажиллагааг бүх нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах	ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100%	үйл ажиллагааны хэрэгжилтээр 100%	Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Говь-Алтай аймагт төлөөлөн 2025 онд хэрэгжүүлэх гэрээний дагуу иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, орон нутагт батлан хамгаалах бодлого, зорилт, зэвсэгт хүчний үйл ажиллагааг аймгийн иргэд, хөдөлмөрчид, цэргийн насны залуучуудад сурталчлах, Зэвсэгт хүчин	100%

					үүсэн байгуулагдсаны 104 жилийн ой, Монгол цэргийн өдрийн хүрээнд Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын эмэгтэй албан хаагчдын дунд мөрдөстэй бүсгүйчүүд чуулга уулзалтыг Говь-Алтай аймгийн Алтай сум дахь хилийн цэргийн 0214 дүгээр ангид зохион байгууллаа. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн санаачилгаар 2025 оныг "Ахлах офицерын жил" болгон зарласантай холбогдуулан Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 104 жилийн ойн хүрээнд "Цол бүхэн сайхан" нэрэмжит тэмцээн, марш-тактик тусгай бэлтгэлийн аварга тасаг, бүлэг шалгаруулах тэмцээн болон энгийн иргэдийн дунд "Засагт хан" буудлагын холбоотой хамтран буудлагын 3 төрөлт тэмцээн, ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд автоматын задаргаа, угсаргаа, магазин сумалгааны тэмцээнийг зохион байгууллаа. Өсвөр үе, хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, Монголын уламжлалт ёс заншил, зан үйл, тоглоом наадтайг түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэх, сурталчлан таниулах, түүх, соёлын өвийг хамгаалах, Монгол хувцасны соёл, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор "Эх оронч Монгол-Өвлөн наадъя" арга хэмжээг аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд аймгийн Боловсролын газар, Соёл урлагийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газруудтай хамтран зохион байгуулж явууллаа. Тус тэмцээнд аймгийн төвийн ерөнхий боловсролын сургуулийн 7 баг оролцлоо.
--	--	--	--	--	---

						Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 104 жилийн ой, Монгол цэргийн баарын өдрийн хүрээнд Зэвсэгт хүчний 123 дугаар анги, Алтай төлөвистэй хамтран "Хугацаат цэргийн алба хаагчийн нэг өдөр" баарын тусгай дугаарын контентыг хийж иргэдэд хүргэсэн. "Алтай" чуулгын уран бүтээлчидтэй хамтран "Эх орон" хүндэтгэлийн тоглолтыг зохион байгуулж Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг аймгийн иргэд, хөдөлмөрчид, цэргийн насны залуучуудад сурталчлан ажилласан.	
2.3	Засгийн газрын тогтоолыг үндэслэн цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийг сургах, алба хаалгах ажлыг зохион байгуулах	ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	40 хүн	100%	Цэргийн дүйцүүлэх албыг 2025 онд биеэр хаах иргэдийг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам"-ыг тус тус үндэслэн сумдаас цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах хүсэлт гаргасан иргэдийн материалыг хүлээн авч, аймгийн Засаг даргын 2025 оны А/247 дугаар захирамжийн дагуу цэргийн дүйцүүлэх албанд 40 иргэнийг элсүүлж, "Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл" сургалтын хөтөлбөрийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс 14 хоногийн хугацаанд Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийг түшиглэн сургалтыг зохион байгуулж явууллаа.	100%
2.4	Сумдын ЗДТГ-ын дарга, багийн Засаг дарга нартай цэргийн бүртгэлийн сургалт, семинарыг зохион байгуулах.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100%	100%	Монгол Улсын дайчилгааны тухай хууль, Цэргийн штабын сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу сумдын багийн Засаг дарга нарын "Цэргийн бэлтгэл" сургалтыг Батлан хамгаалахын сайдын 2020 оны "Цэргийн сургалт бэлтгэлийн хөтөлбөр батлах тухай" А/121 дүгээр тушаалаар батлагдсан "Багийн Засаг дарга нар"-ын сургалтын хөтөлбөрийн	100%

					дагуу хичээлийн хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан нийт 24 цагийн сургалт бэлтгэлийг зохион байгуулж "Төрийн болон албаны нууцыг хамгаалах журам", "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам"-ыг бие бүрэлдэхүүнд танилцуулан нууц хадгалалт хамгаалалтыг чанд мөрдөх, урьдчилан сэргийлэх талаар зааварчилгаа танилцуулан ажигласан.		
2.5	Зэвсэгт хүчний 104 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах.	ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100%	100%	Батлан хамгаалах салбараас 2025 оныг "Эх оронч Монгол-Их сэргэлтийн жил" болгон зарласантай холбогдуулан Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 104 жилийн ойн, Монгол цэргийн өдрийн хүрээнд тус аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабаас 18 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулж аймгийн ЗДТГ-ын даргаар батлуулан биелэлтийг хангаж 03 дугаар сарын 14-17-ны өдрүүдэд зохион байгууллаа. Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын хэрэглэж байгаа зэвсэглэл, багаж хэрэгслийг дэлгэн сурталчлах байгууллагуудын үндсэн үүрэг, үйл ажиллагааны ялгаа онцлогийг таниулах арга хэмжээг иргэдэд сурталчилсан. Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд зохион байгуулах Марш-тактик тусгай бэлтгэлийн аварга тасаг, бүлэг, оны мэргэжлийн аварга офицер, ахлагч шалгаруулах тэмцээний нээлтийн арга хэмжээнд аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын дарга болон, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын удирдлага, алба хаагчид ЗДТГ-ын хэлтсийн дарга нар оролцлоо. Хилийн 0214 анги антид Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын	100%

					эмэгтэй алба хаагчдын "Мөрдөстэй бүсгүйчүүд" чуулга уулзалтыг зохион байгуулсан. Алтай цэргийн хүрээний аварга шалгаруулах марш-тактик тусгай бэлтгэлийн тэмцээнд Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд эрэгтэй 8 тасаг, эмэгтэй 4 тасгийн 112 тамирчин оролцлоо. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн санаачилгаар 2025 оныг "Ахлах офицерын жил" болгон зарласантай холбогдуулан Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд "Цол бүхэн сайхан" нэрэмжит даргс, ширээний теннис, буудлагын тэмцээнийг зохион явууллаа. Уг арга хэмжээнд 11 цолны 44 алба хаагчд өрсөлдөж аваргуудаа шалгаруулсан. Энгийн иргэдийн дунд "Засагтхан" буудлагын холбоотой хамтран том калибр, дурантай бага калибр, ил хараа гэсэн 3 төрлөөр явуулж аваргуудыг шалгарууллаа. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 104 жилийн ойд зориулсан Алтай хотын аварга шалгаруулах бөхийн барилдаанд 56 бөх барилдлаа. Барилдааныг Есөнбулаг сумын ЗДТГ, аймгийн биеийн тамир спортын газартай хамтран зохион байгуулсан. Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн болон Мэргэжлийн боловсролын сургуулийн сурагчдын дунд "Галын бэлтгэлийн норматив", "Магазин сумалгаа"-ны тэмцээнийг зохион байгууллаа.		
2.6	Цэргийн бүртгэл явуулах, хяналт тавих.	ОНТ	Хэрэгжилтийн үр дүн	88,2%	2024 онд 89,1%-тай	Цэргийн бүртгэлийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрүүдэд зохион явуулсан.	100%

				ЗОХИОН ЯВУУЛСАН	Цэргийн бүртгэлээр бэлтгэл офицер, бэлтгэл үүрэгтэн, авто техникийг бүрэн хамруулж цэргийн бүртгэлийн мэдээт батлагдсан маягтын дагуу зөв гаргах, хүн орхигдуулах, давхардуулах, зэрэг зөрчил гаргахгүй байхад анхаарч бүртгэлд хамрагдаггүй иргэдийн судалгааг гаргах, шинээр 18 нас хүрсэн иргэдийн бүртгэлийг хөтлөх, цэргийн үүрэгтний үнэмлэхийг олгох, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийг сурталчлан таниулах, цэргийн үүрэгтний үнэмлэх гээгдүүлсэн иргэдэд үнэмлэх нөхөн олгох зэрэг арга хэмжээг авч ажиллалаа. Цэргийн бүртгэл явагдах хугацаанд сумдын удирдлага, багийн Засаг дарга нарт мэргэжил арга зүйн зөвлөмжийг утсаар өгч, зарим сумдад ажиллаж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн цэргийн бүртгэлийн үйл ажиллагааны явц, бэлтгэл үүрэгтний цэргийн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллав.	100%
	ОНТ	Хэрэгжилтийн үр дүн	88,2%	Үйл ажиллагааны хэрэгжилтээр 100% хүртэл	Монгол Улсын Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн газрын 2024 оны мн/243 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2025 оны мн/05, мн/29 дүгээр тушаалууд, аймгийн Засаг даргын 2025 оны "нэг, хоёрдугаар ээлжийн цэрэг татлага явуулах тухай" А/131, А/522 дугаар захирамжуудыг тус тус удирдлага болгон нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс 05 дугаар сарын 02-ний өдрүүдэд, хоёрдугаар ээлжийн цэрэг татлагыг 10 дугаар сарын 03-ны өдрөөс 17-ны өдрүүдэд цэрэг татах, халах ажлыг зохион байгуулж Зэвсэгт хүчний Жанжин	100%
Цэрэг халах, татах ажлыг зохион байгуулах,	ОНТ	Хэрэгжилтийн үр дүн	100%	Үйл ажиллагааны хэрэгжилтээр 100% хүртэл		

					штабаас өгсөн хяналтын тоог ханган биелүүлээ.	
					Монгол Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан болон Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт нар орон нутагт айлчилсантай холбогдуулан Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн байрлалд баригдах барилга, байгууламжуудыг барихад шаардагдах төсөв, хөрөнгийг 2026 оны улсын төсөвт тусгаж шийдвэрлүүлэх талаар саналыг аймгийн удирдлагуудаар уламжлуулсан.	
					Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийг хугацаат цэргийн алба хаагчидтай болох орчинг бүрдүүлэх асуудлыг шийдвэрлэж, орон нутгийн бүтээн байгуулалтад оролцууллаа.	
2.7	Зэвсэгт хүчний ангийн үйл ажиллагаанд үзүүлэх.	Улсын төсөв	Хэрэгжилтийн үр дүн	50%	Уйл ажиллагааны хэрэгжилтээр 90%-с дээш	100%
					Зэвсэгт хүчний 341 дүгээр ангид хугацаат цэргийн алба хааж байгаа хугацаат цэргийн алба хаагчидтай уулзаж өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах 75 инчийн өнгөт зурагт, 27 сая төгрөгний үнэ бүхий цахим холбооны иж бүрэн техник хэрэгслүүдийг өгсөн Тус ангид малын 2 тонн тэжээлийг аймгийн улсын нөөцөөс олгох ажилд дэмжлэг үзүүлж шийдвэрлүүлсэн.	
					Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн бүтээн байгуулалтад шаардлагатай хайрга, дайрга олборлох газрын асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж, ангийн буудлагын талбай, хүч хуралдуулах болон цугларах районы газрын координатыг төлөвлөн шийдвэрлүүлэхээр аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт хүргүүлсэн.	

2.8	Аймгийн Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын тушаал, шийдвэрийн биелэлт гаргах.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100%	Үйл ажиллагааны хэрэгжилтээр 100%	Аймгийн Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын тушаал, шийдвэрийн биелэлтийг сар, улирал бүрээр гаргаж Засаг даргын бодлого, шийдвэрийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтэнд цаг тухай бүр хүргүүлж ажиллалаа.	100%
2.9	Аймаг, сумдын орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүний дадлага, сургалтыг зохион байгуулах.	ОНТ	Бүрэлдэхүүний тоо	100%	Үйл ажиллагааны хэрэгжилтээр 100%	Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 16.1.1, 17.1.3 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Говь-Алтай аймагт 2025 онд төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний 4.1-т заалт, Батлан хамгаалахын сайдын 2025 оны А/63 дугаар тушаал, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2025 оны А/203 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2025 оны А/537 дугаар захирамж, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны А/63 дугаар тушаалыг удирдлага болгон Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн болон удирдах бүрэлдэхүүний "Хээрийн дадлага" сургалтыг хүн нэг бүр, бүлэг нэгжийн жилд рэлтийг хангах, анхан шатны буудлага гэсэн 3 үе шаттайгаар 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс 10 дугаар сарын 29-ний өдрүүдийн хооронд Есөнбулаг суманд аймгийн Иргэдийн хурлын ажлын алба, аймгийн Засаг даргын Тамгын газрын алба хаагчид зарим агентлаг, газар хэлтсийн мэргэжилтнүүд, 18 сумын ЗДТГ-ын дарга нар болон томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүн, цэргийн ажиллагаанд дэмжлэг үзүүлэх суман, гамшиг, хөнөөх хэрэгслийн хөнөөлөөс хамгаалах сумангийн тасгийн бүрэлдэхүүн нийт 200 иргэнийг хамруулан сургалтыг Есөнбулаг сумын нутагт зохион байгуулж явуулсан. Орон	100%

						нутгийн хамгаалалтын "Хээрийн дадлага" сургалт зохион байгуулахад дүүцүүлэх албаны мөнгөн төлбөрөөс 21.003.000 сая төгрөгийг төсөвлөж сургалтад зарцуулсан. Сургалт зохион байгуулахад шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах, сургалт явуулах аятай нөхцөлийг бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангах, сургалтын хүртээмж, үр дүнг нэмэгдүүлэхэд анхаарч ажилласан.	
2.10	Аймгийн боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд аймгийн Засаг даргын нэрэмжит "Дөл" цогцолбор тэмцээнийг зохион байгуулах.	3.000.0 мян/төг	Тоо: 3 үе шаттайгаар	100%	Захирамж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана. 100%	Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 104 жил, "Эх оронч Монгол-Их сэргэлтийн жил"-ийн хүрээнд Говь-Алтай аймгийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд аймгийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын "Дөл-2025" цогцолбор тэмцээнийг хоёр үе шаттай зохион байгуулсан бөгөөд тэмцээний нэгдүгээр шатыг 2025 оны 04 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд сумууд дотооддоо зохион байгуулж аймгийн аварга шалгаруулах хоёрдугаар шатны тэмцээнийг 2025 оны 05 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд зохион байгуулж шилдгүүдээ шалгаруулсан.	100%
2.11	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын алба хаагчдын ажиглаж, амьдрах нөхцөлийг	-	Бүрэлдэхүүний тоо	60%.	Захирамж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана.	Цэргийн штабын алба хаагчдын ажиллах нөхцөл боломжийг хангаж алба хаагчдын ажлын байранд засвар үйлчилгээ хийж 2 алба хаагчийг	100%

	сайжруулах, эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах;				100%	компьютер бусад шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангасан. Мөн албан хэрэгцээнд DJI брэндийн osmo rocket 3 камер 1, DJI air 3s, DJI AVATA2 маркийн дронууд, notebook-ээр хангасан. Орон нутагт хэрэгжиж байгаа эрүүл мэндийн дэд хөтөлбөрүүд болон аймгийн эрүүл мэндийн газраас зохион байгуулж байгаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, аймгийн ЗДТГ-ын дотооддоо зохион байгуулсан алба хаагчдын эрүүл мэндийн үзлэгүүдэд бүрэн хамруулж ажиллаж байна. Нэгдсэн эмнэлэг болон төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгээс зохион байгуулсан эрүүл мэндийн үзлэг оношилгоонд Цэргийн штабын бүрэлдэхүүнийг хамруулсан.	
2.12	Баруун бүсийн аймгуудын сумдын Тамгын газрын дарга нарын цэргийн бэлтгэл сургалтыг зохион явуулах.	-	Бүрэлдэхүүний тоо	2020 онд баруун бүсийн сургалтад 18 сумдын Тамгын дарга нар оролцсон.	Захирамж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана. 100%	2025 оны 11 дүгээр сарын 06-08-ны өдрүүдэд Завхан аймагт зохион байгуулагдсан баруун бүсийн аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын цэргийн сургалт, бэлтгэлд 18 сумын Засаг даргын Тамгын газрын дарга нар бүрэн хамрагдлаа. Сургалтын бэлтгэл ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2025 оны "Сургалтад оролцуулах тухай" А/581 дүгээр захирамжийг боловсруулан батлуулж, сургалтад оролцох бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсан. Шаардагдах хөрөнгийг цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогоос гарган зарцуулсан. Сургалтад оролцох бүрэлдэхүүнээр нууцын баталгаа гаргуулан, нууц материал, баримт бичиг тээгч notebook, флаш зэргийг аймгийн тагнуулын байгууллагын холбогдох мэргэжилтэнд шалгуулан бүртгүүлж ажилласан.	100%

2.13	"Оюутан цэрэг"-т цэргийн мэргэжил олгох сургалтыг зохион байгуулах.	2.000.0 мян/төг	Хамруулах бүрэлдэхүүний тоо	7 оюутан	Захирамж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана. 100%	"Оюутан цэрэг"-т цэргийн мэргэжил олгох сургалтын журмын дагуу сонгон шалгаруулалтад тэнцсэн 11 оюутанд цэргийн тусгай мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу "Цэргийн ерөнхий бэлтгэл" шатны сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 06-наас 2025 оны 06 дугаар сарын 02-нийг хүртэл хугацаанд Бямба, Ням гарагуудад сургалтыг орон нутагт зохион байгуулж Цэргийн мэргэжлийн бэлтгэл сургалтыг Зэвсэгт хүчний 123 дугаар ангид зохион явуулж тус сургалтад 11 оюутан хамрагдсан.	100%
------	---	--------------------	-----------------------------	----------	---	--	------

3. ИРГЭДЭД ҮЗҮҮЛЭХ ЗАХИРГАНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

3.1	Төрийн батлан хамгаалах үйлчилгээтэй холбоотой иргэний өргөдөл, санал, гомдлыг хуулийн хугацаанд барагдуулах.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	40 иргэн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр 90%-с дээш	Иргэд болон цэргийн жинхэнэ алба хааж байгаа байлдагч нарын ар гэрээс гаргасан гачигдлын шалтгаанаар цэргийн албанаас чөлөөлөх, орон нутгийн түр чөлөө хүссэн, бусад өргөдөл, гомдлыг хүлээн авч бүртгэн зохих шатны байгууллагад уламжлах, шийдвэрлэх хариуг иргэдэд амаар болон утсаар уламжлан шийдвэрлэж ажилласан.	100%
3.2	Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж, цэргийн насны болон өсвөр насны иргэдийн дунд цэрэг-эх оронч хүмүүжил олгоход чиглэсэн 3-аас доошгүй арга хэмжээг зохион байгуулах.	ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100%	Үйл ажиллагааны хэрэгжилтээр 100%	"Эх оронч-Монгол" арга хэмжээний хүрээнд ЕБС-ын ахлах ангийн сурагчдын дунд АКМ-ын задаргаа, угсаргаа магазин сумалгааны тэмцээн, иргэний андгай өргөх ёслолын арга хэмжээн дээр 18 нас хүрсэн бэлтгэл үүрэгтнүүдэд цэргийн үүрэгтний үнэмлэх гардуулсан. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд "Эх оронч үзэл-Үндэсний бахархал" сэдэвт эсээ бичлэгийн уралдааныг зохион байгуулах ажлын хүрээнд сургуулиудад сургалт сурталчилгаа хийж уралдааныг зохион явуулсан. Цэргийн штабаас аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал,	100%

					залуучуудын газартай хамтран 20-25 насны залуучуудын дунд зангиагүй улзалт арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд цэргийн алба, ажлын байрны талаар мэдээ, мэдээллийг хүргэж залуучуудад тулгамдаж байгаа асуудлуудын талаар хэлэлцлээ. “Эх оронч Монгол-Өвлөн наадъя” сэдэвт дэвжээ тэмцээн болон илтгэл, мэтгэлцээн уралдаануудыг тус тус зохион явуулж өсвөр үе, хүүхэд, залуучуудад эх оронч байх үзэл төлөвшүүлэх, Монголын уламжлалт ёс заншил, зан үйл, тоглоом наадгайг түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэх, сурталчлан таниулах, түүх, соёлын өвийг хамгаалах, Монгол хувцасны соёл багаар ажиллах чадварыг нэмэгдүүлсэн. Монгол Улсын ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн ивээл дор төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын ахлах офицеруудын чуулга уулзалтыг утган “Эх оронч үзэл-Үндэсний бахархал” эсээ бичлэгийн уралдааныг 18 сум, 2 тосгоны ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулж, 1 дүгээр байрт Алтай сумын ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагч Д.Мичидмаа, 2 дугаар байрт 3 дугаар сургуулийн ахлах ангийн сурагч Г.Шинэцэцэг, 3 дугаар байрт 1 дүгээр сургуулийн ахлах ангийн сурагч Н.Жавхлантөгөлдөр, 4 дүгээр байрт 1 дүгээр сургуулийн ахлах ангийн сурагч Д.Анх-Эрдэнэ, 5 дугаар байрт 1 дүгээр сургуулийн ахлах ангийн сурагч Б.Манлайбаатар нар шалгарч, өргөмжлөл, мөнгөн шагналаар тус тус шагнууллаа. Шагналыг 2025 оны 06
--	--	--	--	--	--

					дугаар сарын 01-ний өдөр гардууллаа. Тэргүүн байранд шалгарсан Алтай сумын ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагч Д.Мичидмаагийн эсээ улсад тусгай байранд шалгарсан.	
3.3	Цэргийн насны залуусыг эрүүлжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулж, үр дүнг тооцох.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	70%	үйл ажиллагааны хэрэгжилтээр 90%-с дээш	100%
3.4	Хугацаат цэргийн алба хааж буй дайчдын цэргийн албаны үйл ажиллагаатай танилцах, тэдний ар гэрт нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх.	ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100%	үйл ажиллагааны хэрэгжилтээр 70%-с дээш	100%

2024 оны хоёрдугаар ээлжээр цэргийн албанд татагдан Зэвсэгт хүчний 123 дугаар ангид хугацаат цэргийн алба хааж байгаа хугацаат цэргийн алба хаагчидтай аймгийн ЗДТГ-ын дарга, 18 сумын ЗДТГ-ын дарга нар болон эцэг эхийн төлөөлүүд уулзаж анги байгууллага, цэргийн албаны үйл ажиллагаатай танилцан, аймаг орон нутагт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүд талаар мэдээ, мэдээлэл хийж хугацаат цэргийн алба хаах хугацаа дуусаж халагдаж ирсэн залуусыг аймаг орон нутагтаа ажиллаж амьдрах боломж, нөхцөл, ажлын байраар хангахаа аймаг, сумын удирдлагууд мэдэгдсэн. Уулзалтын төгсгөлд хугацаат

					цэргийн алба хаагчдад аймгийн Засаг даргын болон сумын дарга нарын гарын бэлгийг гардуулж, ангийн өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглах 3 үйлдэлт принтерийг ангийн удирдлагуудад гардуулан өгсөн. Зэвсэгт хүчний 256 дугаар ангид хугацаат цэргийн алба хааж байгаа цэргийн алба хаагчдын цэргийн албаны үйл ажиллагаатай танилцах ажлыг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд улсын аварга шалгаруулах цэрэг-спортын "Дөл-2025" цолцолбор тэмцээнд оролцож байгаа баг тамирчдын бүрэлдэхүүн оролцож цэргийн анги байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, хугацаат цэргийн алба хаагчдын амьдрах орчин нөхцөл, цэргийн албаны үйл ажиллагаатай танилцан хугацаат цэргийн алба хаагчдад амжилт хүсэж, баяр хүргэн гарын бэлэг гардуулсан. Зэвсэгт хүчний 341 дүгээр ангид хугацаат цэргийн алба хааж байгаа хугацаат цэргийн алба хаагчидтай уулзаж өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах 75 инчийн өнгөт зургаг өгсөн.	
3.5	Цэргийн албанаас халагдсан иргэдийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх ажлыг хэвшил болгох.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	60%	үйл ажиллагааны хэрэгжилтээр 70%-с дээш	100%

					талаар танилцуулга хийж өөрсдийн сонирхсон ажлын байрандаа бүртгүүлэх ажлыг зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд "Хан-Алтай" ресурс уул уурхайн компанийн ажлын байранд 5 иргэн бүртгүүлж, Зэвсэгт хүчний 341 дүгээр анги болон Цагдаагийн газар, Дотоодын цэрэг, Онцгой байдлын газруудад элсэн ажиллах хүсэл сонирхолтой бэлтгэл үүрэгтнүүдийн баримт бичгийг бүрдүүлэн тухайн байгууллагуудад уламжилсан. Сүлжээндээ үнэгүй, 24 сарын турш сар бүр 60 gb дата болон бусад сүлжээнд сар бүр 500 минут үнэгүй ярих боломжтой "Онжав" дугаарыг Говь-Алтай аймаг дахь Юнителийн салбартай хамтран ажиллаж үнэгүй олгосон.		
					Зэвсэгт хүчний ангид хугацаат цэргийн алба хаасан дайчдаас мэргэжлийн ахлагч бэлтгэх төвд 10 алба хаагч суралцан ахлагчийн албанд шилжсэн.		
4. БАТЛАН ХАМГААЛАХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ТӨРИЙН БОЛОН ХУВИЙН ХЭВШЛИЙН АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ЗОХИОН БАЙГУУЛНА							
4.1	2025 оны цэргийн бүртгэлийн явц сүм, багийн бүртгэлийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн үйл ажиллагааг шалган туслах ажлыг зохион байгуулж, заавар зөвлөмжөөр хангаж ажиллах.	1.200.0 мян/төг	2024 оны тоо бүртгэл	88,2%	2024 онд 89,1%-тай зохион байгуулсан	Цэргийн бүртгэлийн ажлыг иргэдэд сурталчлах, иргэдийн хамрагдалтыг сайжруулах зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, мөн иргэд олноор цуглардаг зах, худалдаа, үйлчилгээний төвүүдэд сурталчилгааны зурагт самбар байршуулан иргэдэд мэдээлэл өгч, хувийн болон төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн удирдлагын шуурхай хурал дээр алба хаагчдаа бүртгэлд хамруулах тухай чиглэл өгч, бэлтгэл үүрэгтний судалгаа гарлуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.	90%

					Аймгийн Засаг даргын сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээ байгуулах, сургалтын хөтөлбөрийн хүрээнд "Цэргийн бүртгэлийг сум, багт зохион байгуулах" сэдэвт сургалтыг "Цэргийн албаны тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4, 34 дүгээр зүйлд заасан хуулийн заалтууд болон "Цэргийн бүртгэл явуулах журам"-ын талаар цахимгаар зохион байгуулсан. Мөн ЗДТГ-аас зохион байгуулсан сум, багийн Засаг дарга нарийн сургалтаар сум, багт цэргийн бүртгэлийг хэрхэн зохион байгуулах, анхан шатны нэгжид нэрийн бүртгэлийг хөтлөх аргачлалыг өгч ажилласан.			
4.2	Цугларах бүрэлдэхүүний дадлагыг зохион тодотгох.	байрын сургалт явуулж	500.0 мян/төг	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100%	Үйл ажиллагааны хэрэгжилтээр 100%	Цугларах, Шилжүүлэх байрын удирдлага, ирц бүртгэх хэсэг, анги, команд зохион байгуулах хэсэг, аж ахуйн тасгийн томилгоот нэгжийн бүрэлдэхүүнтэй сургалтыг явуулж, хөтөлгөдөх баримт бичгүүдийг боловсруулан, хөтөлбөрийг цэргийн штабын даргаар батлуулан сургалтыг зохион байгуулж явууллаа.	100%
4.3	Шилжүүлэх бүрэлдэхүүний дадлагыг зохион тодотгох.	байрын сургалт явуулж	100.0 мян/төг	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100%	Үйл ажиллагааны хэрэгжилтээр 100%	2025 оны цэргийн бүртгэлээр цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол хангасан иргэдийн нэрсийг гарган, мэдэгдэх хуудсыг сумын ЗДТГ-ын даргаар иргэдэд хүргүүлэн төлбөрийг төлүүлэх ажлыг зохион байгуулж байна. 71 иргэний 152,7 сая төгрөгийг төрийн санд төвлөрүүлээд байна. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол хангасан боловч тогтоосон мөнгөн төлбөрийг цаг хугацаандаа төлөөгүй, оршин суугаа хаяг тодорхойгүй иргэдийн төлбөр төлөлтөд аймгийн Шүүх,	100%
4.4	Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзлыг хангасан иргэдийн төлбөр төлөлтөд хяналт тавих, бүртгэл тооцоог хөтлөх		-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	140 сая төгрөг	Үйл ажиллагааны хэрэгжилтээр 70%-дээш		100%

				Прокурорын байгууллагатай хамтран мэдэгдэл хургуулж, эрэн сурвалжилуулах ажлыг зохион байгуулж байна..	
--	--	--	--	--	--

5. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД

5.1	БХЯ, ЗХЖШ-аас зохион байгуулахаар төлөвлөгдсөн сургалтуудад хамрагдах.	ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	3 сургалт	Үйл ажиллагааны хэрэгжилтээр 100%	Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын удирдах бүрэлдэхүүний стратегийн цугларалт, орон нутгийн хамгаалалтын бэлтгэл сургалтын офицеруудын сургалт 2024 оны 09 дүгээр сарын 22-27-ны өдрүүдэд зохион байгуулагдаж сургалтад цэргийн штабын албан тушаалтнууд оролцсон. Мөн Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын удирдах бүрэлдэхүүний цугларалт, 2025 оны 01 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгуулагдсан орон нутаг дахь үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөнүүдэд цэргийн штабын дарга оролцсон	100%
5.2	Орон нутагт явагдах цэргийн сургалтын төлөвлөлтийг боловсруулж, хугацаанд нь сургалтыг явуулах, холбогдох хүмүүсийг татан оролцуулах.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2	100%	2025 оны сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрээнд төлөвлөгдсөн сургалтуудыг хуулийн хугацаанд зохион явуулж холбогдох албан тушаалтан, иргэдийг бүрэн хамруулсан.	100%
5.3	Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдтэй хийх сургалтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	40 иргэн	40 иргэн 100%	Цэргийн дүйцүүлэх албыг 2025 онд биеэр хаах иргэдийг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам"-ыг тус тус үндэслэн сумдаас цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах хүсэлт гаргасан иргэдийн материалыг хүлээн авч, аймгийн Засаг даргын 2025 оны А/247 дугаар захирамжийн дагуу цэргийн дүйцүүлэх албанд 40 иргэнийг элсүүлж,	100%

						“Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл” сургалтын хөтөлбөрийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс 14 хоногийн хугацаанд Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийг түшиглэн сургалтыг зохион байгуулж явууллаа.	
5.4	Цэргийн штабын бие бүрэлдэхүүн офицеруудыг ажлын байран дээрээ суралцах, ур чадвараа дээшлүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж ур дүнг эрхэмлэх.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90%	100%	Цэргийн штабын 2025 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө, Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн 2025 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу цэргийн штабын офицерууд тус ангийн буудлагын талбайд буудлагын 1, 2, 3 дугаар дасгалыг боловсруулан ур чадвараа дээшлүүлэх Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдад хаагчдад шинэчлэн батлагдсан Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмийн талаар болон Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны талаар сургалтыг зохион байгуулж ажилласан. Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А/94 дүгээр тушаалаар батлагдсан “Даргын бэлтгэл” сургалтын хөтөлбөрийн дагуу удирдахуйн ухаан, цэргийн сургалт бэлтгэл, албан хэрэг хөтлөлт ба нууцын горим, цэргийн штабын үйл ажиллагааг сэдвийн хүрээнд нийт 48 цагийн хичээл сургалтыг цэргийн штабын офицеруудад аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэс, Хууль эрх зүйн хэлтэстэй тус тус хамтран зохион байгууллаа.	100%
5.5	Цэргийн штабын офицеруудын сургалтыг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А/94 дүгээр тушаалаар батлагдсан “Даргын бэлтгэл” сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах.	-	Сургалтын хөтөлбөрийн хүрээнд	3	100%	“Даргын бэлтгэл” сургалтын хөтөлбөрийн дагуу удирдахуйн ухаан, цэргийн сургалт бэлтгэл, албан хэрэг хөтлөлт ба нууцын горим, цэргийн штабын үйл ажиллагааг сэдвийн хүрээнд нийт 48 цагийн хичээл сургалтыг цэргийн штабын офицеруудад аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэс, Хууль эрх зүйн хэлтэстэй тус тус хамтран зохион байгууллаа.	100%
5.6	Аймгийн цэрэг татлагын товчоо болон сумдын цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүнтэй цэрэг татлагын сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгуулах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2 удаа	100%	2025 оны нэг, хоёрдугаар ээлжийн цэрэг татлагыг зохион байгуулах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон бүрэлдэхүүн, сум, багийн Засаг дарга нартай цэрэг татлагын өргөтгөсөн хуралдааныг	100%

					зохион байгуулж цэргийн насны залуучууд болон идэрчүүдийн эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулах, цэргийн насны иргэдийн суурь өвчлөл, өнөөгийн нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ цэрэг татлагын ажлыг зохион байгуулах болон Батлан хамгаалах яам, ЗХЖЦЛ-аас өгсөн үүрэг, чиглэлийг танилцуулж ажиллалаа.		
5.7	Сум, багийн Засаг дарга, нарын сургалтыг зохион байгуулах, төсөв хөрөнгийг шийдвэрлэх.	500.0 мян/төг	Сургалтын хөтөлбөрийн хүрээнд	Орон нутгийн төсвөөс санхүүжилтийг шийдвэрлэсэн.	100%	Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион явуулсан сумдын удирдах бүрэлдэхүүнийг чадавхжуулах сургалтын хүрээнд Монгол Улсын дайчилгааны тухай хууль, Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг орон нутагт 2025 онд хэрэгжүүлэхээр Батлан хамгаалахын сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 2.1.5, 3.2 дахь хэсэг, Батлан хамгаалахын сайдын 2020 оны "Цэргийн бэлтгэл сургалтын хөтөлбөр батлах тухай" А/121 тоот тушаал, цэргийн штабын 2025 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөг тус тус мөрдлөг болгон сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарын "Цэргийн бэлтгэл" сургалтыг хамтатган зохион байгууллаа. Сургалтаар Батлан хамгаалахын сайдын 2020 оны "Цэргийн сургалт бэлтгэлийн хөтөлбөр батлах тухай" А/121 дүгээр тушаалаар батлагдсан "Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нар"-ын сургалтын хөтөлбөрийн дагуу хичээлийн хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан нийт 24 цагийн сургалт бэлтгэлийг зохион байгууллаа. Сургалтаар батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх, цэргийн штабын бэлэн	100%

					байдалыг хангах, дайчилгааны бэлтгэл нөөцийн болон орон нутгийн хамгаалалтын сургалт бэлтгэлийн хангах, томилгоот бүрэлдэхүүнийг тодотгож үүрэг гүйцэтгэх чадавхийг нэмэгдүүлэх асуудлуудын хүрээнд мэдээлэл өгч, хууль эрх зүйн зохицуулалт, гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах арга зүй, анхаарах асуудал, гамшгийн үеийн холбоо, зарлан мэдээлэл дамжуулахад анхаарах асуудал, ажлын байрны сэтгэлзүй, батлан хамгаалах бодлого, дадлага ажлыг явуулж санал хүсэлтийг сонсож, нэгдсэн ойлголтод хүрч цаашид анхаарах зарим чиглэлийн талаар үүрэг өгч "Төрийн болон албаны нууцыг хамгаалах журам", "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам"-ыг бие бүрэлдэхүүнд танилцуулан нууц хадгалалт хамгаалалтыг чанд мөрдөх, урьдчилан сэргийлэх талаар зааварчилгаа танилцуулан ажилласан.		
6. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ							
6.1	Нутаг дэвсгэртээ батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг сурталчлах.	ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100%	100%	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт батлан хамгаалах салбарын талаар тусгагдсан зорилтуудаас орон нутагт хамааралтай заалтуудыг аймгийн Засаг даргын 2020-2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөө, аймгийн ЗДТГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөө, цэргийн штабын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө зэрэг бодлогын бичиг баримтуудад батлан хамгаалах бодлого, хууль тогтоомж үйл ажиллагааг тусган сурталчлан хэрэгжүүлж ажиллалаа.	100%

6.2	Цэргийн албаны тухай хуулийн дагуу ээлжит цэрэг татлагын ажлыг зохион байгуулах.	ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2 удаа	100%	Монгол Улсын Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн газрын 2024 оны мн/243 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2025 оны мн/05, мн/29 дүгээр тушаалууд, аймгийн Засаг даргын 2025 оны "нэг, хоёрдугаар ээлжийн цэрэг татлага явуулах тухай" А/131, А/522 дугаар захирамжуудыг тус тус удирдлага болгон нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс 05 дугаар сарын 02-ний өдрүүдэд, хоёрдугаар ээлжийн цэрэг татлагыг 10 дугаар сарын 03-ны өдрөөс 17-ны өдрүүдэд зохион байгуулж Зэвсэгт хүчний Жанжин штабаас өгсөн хяналтын тоог ханган биелүүллээ.	100%
6.3	Орон нутгийн хамгаалалт болон дайчилгааны даалгавар биелүүлэх чадамжийг дээшлүүлэх.	ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	80%	"Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө", "Орон нутгийн цэргийг байгуулах бэлтгэлийг хангах төлөвлөгөө"-г тодотгон, сумдын орон нутгийн цэргийн отряд, сумангийн хүн, хүч, машин техникуудийг томилгоожуулах хүнс, шатах тослох материал, сум, галт хэрэгслийн тооцоог гарган сумдын орон нутгийн цэргийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах томилгоот бүрэлдэхүүн, хүч хэрэгслийг тодотгон нөхөн хангалт хийж ажиллалаа.	70%
6.4	Засгийн газрын тогтоолыг үндэслэн цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэдэд төлбөрийн хэмжээг тогтоон, төлүүлж, аймгийн төрийн сангийн дансанд төвлөрүүлэх.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	174 сая	100%	Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг зарцуулах журмын дагуу хугацаат цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнүүдийн нарсийг гарган мөнгөн төлбөр төлөх мэдэгдэх хуудас хүргүүлж ажилласан бөгөөд Төрийн сан	100%

					банкнд 152.7 сая төгрөгийн мөнгөн төлбөрийн орлогыг төвлөрүүлээд байна. Аймгийн улсын дайчилгааны төлөвлөгөө боловсруулагдан батлагдсантай холбогдуулан сумдад дайчилгааны даалгавар тогтоох, дайчилгааны төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажлыг хангах талаар сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарын "Цэргийн бэлтгэл" сургалтын хүрээнд үүрэг чиглэлийг өгч мөргөжил, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан. Сумдын дайчилгааны даалгаврыг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар томилон ажилласан. Завхан аймагт зохион байгуулагдсан баруун бүсийн аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын цэргийн сургалт бэлтгэлийн үеэр аймгуудын улсын дайчилгаа хариуцсан мөргөжилтнүүдтэй Батлан хамгаалах яамны Орон нутгийн хамгаалалт, дайчилгааны газрын дарга тусгайлан сумдад дайчилгааны даалгавар хэрхэн тогтоох тухай, дайчилгааны даалгавар тогтоох тухай аймгийн Засаг даргын захирамжийг хэрхэн боловсруулах, дайчилгааны даалгавар тогтоосон танилцуулгыг бэлтгэх талаар мөргөжил, арга зүйн зөвлөгөөг өгсөн. Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт сумын дайчилгааны төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай тооцоо судалгааг хэрхэн боловсруулах талаар сургалт, мөргөжил, арга зүйн дэмжлэгийг Батлан хамгаалах яамны Орон нутгийн хамгаалалт, дайчилгааны газраас үзүүлсэн.	
6.5	Улсын дайчилгааны даалгаврыг шинэчлэн боловсруулах, тодотгоход мэргэжлийн дэмжлэг үзүүлэх.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	70% дээш	90%

6.6	Дайчилгааны даалгаврын дагуу Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 304 дүгээр тусгай салбартай тогтоосон хугацаанд тодотгол хийх.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	1 ангийн 1 команд	100%	Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 304 дүгээр тусгай салбарын дугаар командад хүн, техникийг оногдуулан бүртгэж тодотголыг цаг хугацаанд нь хийж ажиллалаа.	100%
6.7	Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг даалгаваржуулах.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	100%	"Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө", "Орон нутгийн цэргийн бэлтгэлийг хангах, байгуулах төлөвлөгөө"-ний дагуу иргэдийг оногдуулан бүртгэж, байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн гар дээр байгаа галт зэвсэг, машин техникүүдийг даалгаваржуулсан.	100%
6.8	Аймгийн цэрэг-стратегийн үнэлгээг нийгэм, эдийн засгийн статистик үзүүлэлтэд үндэслэн цэргийн ажиллагаанд үзүүлэх нөлөөг тооцон дүгнэлт гаргах.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2 удаа	100%	Аймгийн цэрэг-стратегийн үнэлгээг нийгэм, эдийн засгийн статистик үзүүлэлтэд үндэслэн цэргийн ажиллагаанд үзүүлэх нөлөөг "Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө", "Орон нутгийн цэргийн бэлтгэлийг хангах, байгуулах төлөвлөгөөнүүдэд тусган ажилласан.	100%
6.9	Улсын дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэх, мэдээлэл боловсруулахад хамтран ажиллах.	ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	100%	Улсын дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд аймгийн нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, цэргийн дайчилгааны үеийн удирдлага, дайчилгааны бэлэн байдлын түвшин, дайчилгааны бэлтгэл нөөцийн байдал, цэргийн дайчилгаа явуулах боломж, техникийн судалгаа, төлөвлөгөө батлуулахад шаардагдах лавлах өгөгдөлүүдийг бэлэн болголоо.	100%
6.10	Албан байгууллагаас ирсэн төрийн болон цэргийн нууц баримт бичигт бүртгэл хяналтын карт хөтөлж, хугацаанд нь шийдвэрлэх.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100%	100%	Цэргийн штабын маш нууц, нууц баримт бичиг, ном материалын 2025 оны хагас, бүтэн жилийн тооллогыг явуулж өгүүлбэр актыг 3 хувь үйлдэн хувийг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабт тус тус хүргүүлсэн. Сумдад ашиглагдан хадгалагдаж байгаа	100%

						нууц баримт бичгийн хадгалалт хамгаалалт болон батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа байдалд шалган туслах ажлыг явуулж ажилласан.	
6.11	Тус хэлтэст хадгалагдаж байгаа төрийн болон албаны нууц материалуудад хатас жил болон жилийн эцсийн нууцын тооллогыг хугацаанд нь зохион явуулах.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2 удаа	100%	Цэргийн штабын дайчилгааны бэлэн байдлын онц чухал-маш нууц, маш нууц, нууц баримт бичиг, ном материалын тооллогыг зохион байгуулж өгүүлбэр актыг 3 хувь үйлдэн нэгдүгээр хувийг Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газарт, хоёрдугаар хувийг Зэвсэгт хүчний Жанжин штабын Бодлого стратегийн төлөвлөлтийн газарт тус тус хүргүүлсэн.	100%
6.12	Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулж буй сар улиралын хуваарьт ажлуудыг чанартай зохион байгуулах.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100%	100%	Аймгийн ЗДТГ-аас зохион явуулсан цаг үеийн арга хэмжээ, хурал зөвлөгөөнүүдэд тогтмол оролцож Галын тахилга, мод тарих зэрэг томоохон бүтээн байгуулалтын ажилд цэргийн штабын бие бүрэлдэхүүн оролцсон.	100%
6.13	Хугацаат мэдээ тайланг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штабт хүргүүлэх.	-	Сургалтын нэгдсэн төлөвлөгөөний биелэлт -	100%	100%	Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабт үйл ажиллагааны мэдээ тайланг хуваарийн дагуу нэгтгэн хүргүүлж ажиллалаа.	100%

Төлөөлөгсөөг үнэлсэн:
Говь-Алтай аймгийн Басал даргын Тамгын газрын дарга
Төсвийн шууд захирагч
/Ш.Эрдэнэбат/

Тайлагнасан:
Цэргийн штабын дарга
хурандаа
Нэгжийн дарга
/Д.Төмөрбаатар/

